



ХААИС-д

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ  
ХЭРЭГЛЭЭНИЙ ШИНЖЛЭХ УХААН,  
ИНЖЕНЕРЧЛЭЛИЙН СУРГУУЛЬ

14201 Улаанбаатар хот-46а ш/х-600  
Сүхбаатар дүүрэг, Их сургуулийн гудамж 3,  
Утас: 32-56-31, Факс: (976-11) 32-56-31,  
И-мэйл: dean@seas.num.edu.mn, Вэб: http://seas.num.edu.mn

2022-09-12 № \_\_\_\_\_  
танай 2022-09-05 -ны № 01/214 -Т

Санал хүргүүлэх тухай

Агроэкологи Сургууль Таримал Судлал, тэнхимийн 2022-2023 оны хичээлийн жилд “Ландшафтын архитектурын үндэс” хичээлийг ХААИС-ын сургалтын журмын дагуу шинээр болон шинэчлэн боловсруулж байгаа хичээлийн хөтөлбөрийн талаар МУИС-ын зүгээс дараах саналыг хүргүүлж байна. Үүнд:

“Ландшафтын архитектурын үндэс” хичээлийн хөтөлбөрт ландшафтын архитектур төлөвлөлт үндсэн зарчим хэв маяг, ландшафтын гоо сайхан, хөгжил тохижилт, ач холбогдол, ландшафтын архитектурын судалгаа, ангилал, ландшафтын дизайн, элментүүд гэрэл сүүдэр бүтэц хэмжээ өнгө зураглал гаргах талаар онол, дадлага практикийн арга зүйн талаар суурь мэдлэг эзэмшүүлэхийн зэрэгцээ өнөө үед маш чухал шийдэл болох ландшафтын архитектурын өргөн хэрэглэгддэг хэлбэр зохиомжийг онолд суурилан практик ур чадваруудыг эзэмшүүлж байгаа нь оюутан судлаачдын эрэлт хэрэгцээнд нийцэж байна.

Оюутан залууст онол практикийн анхан шатны мэдлэг арга барил олгоход дөхөмтэй арга зүйн ач холбогдол бүхий сэдвүүдийг агуулгад тусгаж өгсөн нь хөтөлбөрийн үнэ цэнэ улам өргөжих болно.

**Хөтөлбөрт өгөх санал:**

Лекцийн хичээл:

- 1. Ландшафтын архитектурын өнгөрсөн ба өнөө үе ландшафтын архитектурын үндсэн объектын талаар тодорхой тусгаж өгөх
- 2. Ландшафтын урлагийн онол, нутаг дэвсгэрийн орон зайн төлөвлөлтийг түлхүү оруулах
- 3. Тусгай зориулалт болон хүндэтгэлт газрын цэцэрлэгжүүлэлт төлөвлөлтийн онцлог, туршлага, архитектурын шийдэл
- 4. Байгалийн ландшафтын элементүүд, ландшафтын төлөвлөлтийн аргыг газарзүйн мэдээллийн системтэй холбосон товч тодорхой сэдэв нэмж оруулж өгөх нь зүйтэй.

**Дадлага хичээл:** Шилмүүст навчит мод сөөгний зөв зурах дүрслэл гаргах, тэмдэглэгээ, орон зайн 3-н хэмжээст байгуулалт, өнгө гаргах мод сөөгний талбайн перспектив байгуулалтын талаар тодорхой тусгажээ гэсэн ч зөвхөн тухайн дүрслэл гаргах мод сөөгний экологи биологийн онцлог мод сөөгний монгол, орос, латин нэршлийг дурдсан сэдэв огт ороогүй байна. Жишээлбэл: Ой бүрдүүлэгч голлох шилмүүст навчит мод болон туслах мод сөөгний биологи (чимэглэлийн мод сөөг) экологи морфологи, онцлог, шилмүүст, навчит мод, бут сөөгний гол төлөөлөгчдийн латин, орос монгол нэрсийг товч бөгөөд тодорхой сэдэв оруулах нь зүйтэй.

**Суралцагчдын мэдлэг ур чадварыг үнэлэх шалгуур дээр**

- Бие даалт хийж бичих, илтгэх,
- Багаар ажиллах,
- Цагийн менежменттэй байх

САНАЛ БИЧСЭН  
ХБООИТЭНХМИЙН БАГШ ДЭД.ПРОФЕССОР

Б.ЦЭНГЭЛ